

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-4
1. Хэлэлцэх асуудлын тухай	3-4

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны намрын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
09 дүгээр сарын 22-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 37 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Д.Ганмаа, Х.Жангабыл, С.Замира;
Тасалсан: Ж.Батсуурь, С.Ганбаатар, Ц.Мөнхтуяа, Б.Пунсалмаа,
Р.Эрдэнэбүрэн.

Байнгын хорооны хуралдаан 14 цаг 40 минутаас 17 цаг 50 минутад завсарлав.

Байнгын хорооны дарга О.Номинчимэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5-д заасны дагуу хэлэлцэх асуудлыг хойшлуулав. /17:51/

Хуралдаан 04 минут үргэлжилж, 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Өргөдлийн байнгын хорооны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хороодын гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул өнөөдөр буюу 9 сарын 22-ны өдрийн хуралдаан нээлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Хүрэлбаатарын Баасанжаргал, Жаргалсайханы Золжаргал, Одсүрэнгийн Номинчимэг, Мягмардашийн Сарнай, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат, Дүгэрийн Рэгдэл, Чинбатын Ундрэм, Жанчивын Галбадрах, Ганзоригийн Лувсанжамц, Отгоны Саранчулуун нар оролцож байна. Ирвэл зохих 21 гишүүнээс 11 гишүүн буюу 52,4 хувьтай ирц бүрдсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал байгаа.

1 дүгээрт Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх буюу оршуулгын газрын эмх цэгц, эрх зүйн шинэчлэлийг хийх талаар хуулийн төсөл санаачлах тухай нийтийн өргөдлийг хэлэлцэнэ.

2 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 8 сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/-ийг хийнэ.

3 дугаарт Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг хийнэ.

Ингээд өнөөдөр одоо яг чуулган хуралдаж, Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох асуудал бас зэрэгцэж байгаа учраас энэ асуудал дуустал Байнгын хорооны хуралдааныг түр завсарлууллаа.

14.40 цаг.

О.Номинчимэг: 2026 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан 10 цаг 30 минутад төлөвлөсөн байсан боловч ирц бүрдэхгүй байсаар 14 цаг 30 минут болсон. Одоо ингээд бас ажлын цаг дуусах гэж байна. 15 цаг 50 минут болж байна.

2 дугаарт тухайлсан асуудлаар тодорхой сайд нарыг тухайн яамны албан тушаалтантайгаа заавал хэлэлцэх асуудал дээр орж ирэх албан бичгийг, шаардлагыг бас явуулсан. Энэ ажлын хэсэгт албан тушаалтнууд болон сайд нар

ирээгүй учраас асуудлуудыг дэгийн хуулийн дагуу хойшлуулахаас өөр аргагүйд хүрч байна.

Тэгэхээр өнөөдрийн Өргөдлийн байнгын хорооны хуралдааныг хааж, энэ 7 хоногт даргын дэргэдэх зөвлөлөөр дахин товлох хүртэл хаасныг мэдэгдье.

17.51 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ